



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛААР ӨГӨГДСӨН
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ
2026 он



**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛААР ӨГӨГДСӨН
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026.02.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Тайлант хугацаанд Зам, тээврийн сайдын тушаалаар яамны нэгжүүд болон харьяа байгууллагуудад 522 үүрэг, даалгавар өгөгдсөн байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 393, хэрэгжих шатанд 38, хэрэгжээгүй 39, хугацаа болоогүй 31, хүчингүй болсон 18 арга хэмжээний хэрэгжилт дунджаар **87.7** хувь байна.

Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

№	Газрын нэр	Нийт заалт	Үүнээс (хувиар)					Биелэлтийн хувь
			хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	хэрэгжээгүй	Х.Б	Хүчингүй болсон	
1	ТНБД	18	13	0	5	0	0	72.22
2	БТГ	20	19	0	0	0	1	100.0
3	ТЗУГ	48	37	6	5	0	0	83.33
4	ХШУДАГ	110	80	12	11	4	3	83.50
5	АЗБЗГ	54	44	6	2	2	0	90.38
6	АТБЗГ	23	19	3	0	1	0	93.18
7	СХГ	19	15	3	0	1	0	91.67
8	СХОГ	3	3	0	0	0	0	100.0
9	ИНБЗГ	67	54	5	3	1	4	91.13
10	ИНУТ	15	10	2	0	1	2	91.67
11	ИНЕГ	87	48	4	5	19	11	87.72
12	МИАТ	6	3	0	0	0	3	100.0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

13	АХОЗШША	4	2	1	0	1	0	83.33
14	ТЗГ	29	23	2	1	2	1	92.31
15	ТЗДТБЗГ	59	48	1	9	0	1	83.62
16	ЗТХТ	15	12	0	0	3	0	100.0
17	АТҮТ	18	17	0	1	0	0	94.44
18	УБТЗ	34	29	2	2	1	0	90.91
19	МТЗ	32	26	4	0	1	1	93.33
20	ТТЗ	16	13	2	1	0	0	87.50
21	Далайн захиргаа	20	17	2	1	0	0	90.0
22	ХХНОБ	6	4	0	0	0	2	100.0
Нийт		522	396	38	39	31	18	87.74

Зам, тээврийн яам, агентлаг, харьяа байгууллагын хэмжээнд сайдын тушаалын хэрэгжилт 75.29%-тай, байгаа бөгөөд **(хэрэгжээгүй)** 8.5%-тай, арга хэмжээ нь томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил, төсөв санхүүтэй холбоотой байна.

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, аргачлалд орсон өөрчлөлтөөр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг **(хэрэгжсэн), (Хэрэгжих шатанд), (хэрэгжээгүй), (Хугацаа болоогүй), (Хүчингүй болсон)**, гэсэн үнэлгээгээр үнэлсэн бөгөөд, холбогдох газар нэгж тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүй байна.

Зам, тээврийн яам агентлаг, газар, нэгжүүд сайдын тушаалын хэрэгжээгүй заалт тус бүрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгаа тул өмнө онд хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон болон хүчингүй болсон тушаалыг хяналтаас хасаж, өмнөх оны **(Хэрэгжих шатанд), (хэрэгжээгүй)** арга хэмжээг энэ оны хагас жилд багтаан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гурав. Санал, зөвлөмж

Зам, тээврийн салбарын 2025 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дагуу тухайн чиг үүргийг хариуцсан албан хаагчдын өгсөн санал, зөвлөмж бүрийг хэрэгжүүлэн ажиллахын хамт Сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгавартай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. **Үүнд:**

3.1. Зам, тээврийн сайдын тушаалаар удирдах ажилтнууд гадаад томилолтоор ажилласан тохиолдолд холбогдох журамд заасны дагуу Гадаад хамтын ажиллагааны хэлтэс (цаашид “ГХАХ” гэх) тайлагнаж хэвших, томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллахыг Яам, агентлаг, газар, хэлтсүүдэд;

3.2. Сайдын тушаалын хэрэгжээгүй заалт тус бүрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, өмнөх онд хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон болон хүчингүй болсон тушаалыг хяналтаас хасаж, өмнөх оны **(хэрэгжээгүй)** арга хэмжээг энэ оны хагас жилд багтаан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Яам, агентлаг, газар, хэлтсүүдэд;

3.3. “Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг журамд заасан хугацаанд Засгийн газарт тайлагнасан байдлыг харгалзахын хамтаар гүйцэтгэлийн үр дүнгээс хамаарч **(хэрэгжсэн), (хэрэгжих шатанд), (хэрэгжээгүй), (Хугацаа болоогүй), (Хүчингүй болсон)** гэсэн үнэлгээгээр үнэлэхээр болсон тул Яамны газар хэлтсүүд хэрэгжилтийг чанартай, үнэн зөв, бүрэн тайлагнаж, цаглабарт заасан хугацаанд Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлж хэвших;

3.4. “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.2-т заасны дагуу “Байгууллагын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн асуудал хариуцсан ажилтан” хэрэгжилтийн тайланг энэ журмын 2 дугаар хавсралтад тусгасан маягтын дагуу нэгтгэж, байгууллагын хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгжид хүргүүлэн” гэж заасны дагуу ажиллаж хэвшихийг Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус зөвлөж байна.